Толбо сумын Ерөнхий боловсролын нь бага дунд боловсрол олгох чиг үүрэг бүхий байгууллага.

Ерөнхий боловсролын тайлант оны зорилгыг “Сурах хүсэлтэй, өөрийгөө илэрхийлэх чадвартай, эрүүл бие бялдартай хүүхэд төлөвшүүлнэ” гэж тодорхойлсон байна.

Зорилгыг биелүүлэх хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Боловсролын ерөнхий хууль, сургуулийн өмнөх болон ЕБС-ийн тухай хуулийг сурагч, багш, эцэг эхэд сурталчлан таниулж мөрдлөг болгон ажиллана
2. Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал, явцын үнэлгээнд суурилан сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ
3. Англи хэлний PERSON, бага ангийн EDUTEN хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, medlee.mn сургалтын үндсэний нэгдсэн платформ ашиглан суралцах, тэгш боломж бүрдүүлнэ
4. Дотуур байрны орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалж сургах, хөгжих орчин бүрдүүлнэ
5. Монгол хэлний сургалтыг сайжруулах цогц бодлогын хүрээнд ажил зохион байгуулна
6. Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургана
7. Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг харгалзан багш нарт дэмжлэг үзүүлнэ
8. Сургалтандаа АХИС-ийн арга зүйг байнгыг хэрэглээ болгоно

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Толбо сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хууль, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг зарим хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Сургуулийн 2021, 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Толбо сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн захиралын 2020 оны 06 сарын 16-ны өдрийн А/17 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Толбо сумын Ерөнхий боловсролын сургууль 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17.9 сая төгрөгөөр буюу 1.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	124,034.20	282,589.70	158,555.5
Авлага	6,547.00	539.80	6,007.20
Урьдчилгаа			
Бараа материал	122,876.10	132,341.30	- 9,465.20
Үндсэн хөрөнгө	2,016,357.90	2,095,528.00	- 79,170.10
Нийт хөрөнгө	2,269,815.20	2,510,998.80	- 241,183.60
Өр төлбөр	10,432.10	0.00	10,432.10
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,259,383.10	2,510,998.80	- 251,615.70
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,269,815.20	2,510,998.80	- 241,183.60

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг дансанд өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө оны эцэст 282.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч оны эхнээс 158.6 сая төгрөгөөр өссөн байна.Зарцуулагдаагүй төсвийн дийлэнх үлдэгдлийг цалин, урамшуулалын зардал, бараа үйлчилгээний бусад зардал зардал, үдийн цай, хоол, мэдээлэл технологийн үйлчилгээний зэрэг зардлууд эзэлж байна.Орон нутгийн төсвөөс 40.4 сая төгрөгийн төсвийг дутуу авсан байна.

Оны эхэнд байсан ажиллагсадтай холбоотой үүсэн авлагаас 6.0 сая төгрөгийн авлагыг барагдуулсан байна.

Бараа материалын үлдэгдэл 8.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.Төсвийн хөрөнгөөр 266.3 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 29.9 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 286.7 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 132.3 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарсан байна.Акталсан бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 180.2 сая төгрөгөөр нэмэгдсэн.Төсвийн хөрөнгөөр 33.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авч, бусад эх үүсвэрээр нийт 146.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авсан байна.Акталсан болон шилжүүлсэн үндсэн хөрөнгө байхгүй байна.Үндсэн хөрөнгөд 101.0 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүнгээр 251.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3121.6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 3121.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж төсвийн төслийн саналаас 1107.1 сая төгрөгөөр бууруулан, 2014.5 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдсэн байна.Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 17 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 3162.4 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 343.4 сая төгрөгийг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 126.7 сая төгрөгийн, нийт 3,632.6 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3162.4 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 302.сая төгрөгийн санхүүжилтийг авч, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 2.0 сая төгрөгийн орлогыг оруулж, оны эхний үлдэгдлээс 123.6 сая төгрөг зарцуулсан байна.

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,308.8 сая төгрөг буюу 91.1 хувьтай, дансанд 282.5 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна.Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	4,347.30	4,347.30	0.00	100.00
80233	Хїхэд хамгаалал	4569.2	4569.2	0.00	100.00
80312	Сургалт семинар	3,123.90	3,123.90	0.00	100.00
81605	Эрүүл мэндийг дэмжих	4,347.30	4,256.10	91.20	97.90
81801	үдийн цай хөтөлбөр	79,323.50	76,466.70	2,856.80	96.40
81806	Дотуур байрны үйлчилгээ	631,160.80	567,119.40	64,041.40	89.85
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	32,642.10	32,629.50	12.60	99.96
81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	13,054.50	1,950.00	11,104.50	14.94
81827	Бичиг үсгийн боловсролын хөтл	21,814.50	21,814.50	198,135.30	91.77
81834	Боловсролын стандарт, сургалты	2,406,071.90	2,207,936.60	2,528.30	96.80
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	78,890.20	76,361.90	1,060.00	65.58
81848	Сурах бичгийн тїрээс	3,080.00	2,020.00	3,457.80	48.82
81875	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	6,756.40	3,298.60	40,438.69	88.22
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	343,400.00	302,961.31	323,726.59	91.09
	Дүн	3,632,581.60	3,308,855.01	3,779.90	91.08

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн тайлангийн аудитын ерөнхий чиглэлийн судалгааны талаар:

Цалингийн сангаас ахмадын санг бүрдүүлээгүй.Худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.Босго үнэ буюу 20.0 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий хоолны зардлыг тендер зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулаагүй байна.

Тайлант онд 96 орон тоогоор ажилласан.Урьд он буюу 2023 онд нийт 98 орон тоогоор ажилласныг 2 хүнээр бууруулсан байна. Сурах бичгийн түрээсийн орлогоос 2.0 сая төгрөгийг оруулсан.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Толбо сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Толбо сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь батлагдсан төсвийн хүрээнд 266.3 сая төгрөгийн бараа материал, 33.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 09 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Толбо сумын Ерөнхий боловсролын сургууль 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 2,533.2 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 25.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,644.2 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 36.4 сая төгрөг болж байна.

Толбо сумын Ерөнхий боловсролын сургууль нийт орлого, зардалд өмнөх оноос өөрчлөлт орсон байх тул материаллаг байдлыг гүйцэтгэлийн шатанд шинээр тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

44.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтийн хангаж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил дараах зөрчлүүд илэрсэн.

1.Тайлант оны эхэнд худалдан авалтын төлөвлөгөөг гаргаж, батлуулаагүй, хоолны зардлын нийт төсөвт тендер зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулаагүй, шууд гэрээ хийх замаар худалдан авалт хийж ирсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ”, 14.2-т “Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ”, 4-т “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жилийн эхэнд батлуулж, 20.0 сая төгрөгнөөс дээш өртөгтэй бараа, ажил үйлчилгээг худалдаж авах захиалгыг сумын ТТЗ-д нэгтгүүлэн, худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийг зөвлөмж болгов.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгав.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 454.8 сая төгрөгийн 24 мөнгөн гүйлгээг , 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын

3586.0 сая төгрөгийн 18 мөнгөн гүйлгээг Шилэн дансанд байршуулан ажилласан байна. Шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100.0 хувьтай байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн. Аудитаар уулзалт хийж, байгууллагын талаар мэдээлэл, дотоод аудитын талаар мэдээлэл авч, холбогдох ажлын баримтуудыг цуглуулсан. Нөлөөллийн мэдүүлгийн баримтыг танилцуулж, гарын үсэг зуруулж, уулзалтын тэмдэглэлийг баримтжуулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар дийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг хуулийн 6 дугаар зүйл, 10 дугаар зүйлийн 10.7-д заасны дагуу зохион байгуулах арга хэмжээ авч ажиллан, үдийн хоолны өдөр бүрийн талоныг хянаж баталгаажуулах, аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг дүгнэх, хяналтыг хуульд заасны дагуу хэрэгжүүлээгүй,

Шилэн дансанд мэдээлээгүй цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш зарлагын 46626.9 мянган төгрөгийн 4 гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд нөхөн байршуулж зөрчлийг арилгах зөвлөмж өгөгдсөн.

Сургуулийн дотуур байрны багш ид илүү олгосон 374.4 мянган төгрөгийн цалинг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон байна.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг давтан шалгаж үзэхэд зөрчлийг арилган ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт /мянган төгрөгөөр/		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	374.4	1	374.4	100%
Албан шаардлага					
Зөвлөмж	2	108,648.9	2	108,648.9	100%
Нийт дүн	3	109,023.3	3	109,023.3	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж цалин тогтоолт, олголтыг бүрэн шалгаж амжаагүй тул дараагийн аудитаар цалинг үнэн зөв олгосон эсэхийг дахин шалгах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй байна.

Аудитаар нийт 51,314,6 мянган төгрөгийн зөрчил илэрч 156.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 51,158.6 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар 156.0 мянган төгрөгийн төлбөрийн 1 акт тогтоов.

1. Цалингаас суутгасан ХХОАТ-ын тооцоог шалгаж үзэхэд 156.0 мянган төгрөгийн татварыг дутуу төвлөрүүлж, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.3 “бүх өр төлбөр”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-д “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлогоос 10 хувиар тооцож албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх”, Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д “бусдад олгох хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож, тогтоосон хугацаанд төсөвт төлөх” гэсэн заалтад нийцэхгүй байна.

2. Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн актыг хугацаанд төлж, төсвийн орлого болгох.

5.2 Албан шаардлага

Аудитаар 2,513.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгөв.

1. Санхүүгийн ажилтнуудад цалингаас 2,513.0 мянган төгрөгийн балансын шагнал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Аудитаар 48,645.6 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Сургууль нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй /дотуур байрны хоол хүнс 174.7 сая төгрөг, үдийн хоол 79.3 сая төгрөг г.м/ байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1-т Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.”, 46.1-т “Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана.” гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

2. Шатахууны төсвийн зарцуулалт, тооцоотой холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

“Толбо ойл” ХХК-наас жилийн турш худалдан авсан 8,467.4 мянган төгрөгийн шатахууны ямар ажлаар явсаныг замын хуудас хөтөлж баримтжуулаагүй, шатахуун хүлээн авсан хүний гарын үсэггүй, зарцуулалтанд тхяналт тавьж ажиллаагшгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” , 14.1.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана”, 14.4.5-д “бүх орлого”, 14.4.6-д “бүх зардал” гэсэнтэй нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7, 14.1.1, 14.4.5, 14.4.6 дахь заалтыг баримтлан, шатахуун зарцуулалтанд тавих хяналтыг зохих журмын дагуу хэрэгжүүлж ажиллах;

3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Цалингийн зардлын төсвөөс ажилчдад 40,178.2 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлтийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”-тай нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”-ыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний **төлөвлөгөөг** аудитын тайланг хүлээн авснаас хойш **30 хоногийн дотор ирүүлэх,**

Зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн	0	0	0	0	0	0	0	0	0			

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Татварыг дутуу төлсөн	1	156.0	1	156.0								
Балансын шагнал олгосон	1	2,513.0			1	2,513.0						
Шатахууны зарцуулалтад тавих хяналт сулруулсан	1	8,467.4					1	8,467.4				
Цалингийн зардлаас түлээ нүүрсний хөнгөлөлтийг олгосон	1	40,178.2					1	40,178.2				
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй	1						1					
Дүн	4	51,314.6	1	156.0	1	2,513.0	3	48,645.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	1	0					1	0